Эрүүл Мэндийн Газар Хяналт Шинжилгээ Үнэлгээ Мэдээлэлийн Хэлтэсээс бэлтгэн гаргав

Мэдээ хянасан
ХШҮМ*Х-ийн дарга Д. Наранмичид*

Мэдээ нэгтгэсэн
Мэргэжилтэн *Т. Уганжаргал*

Утас : 70562096
Вэб сайт:mohs.khe.gov.mn

Эх, хүүхдийн эрүүл мэнд
/2021 оны 4 сарын байдлаар/

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 4 сарын байдлаар нийт 527 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 25 төрөлтөөр буюу 4.5 хувиар буурсан байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 78,5% /414/ нь сумдаас ирж төрсөн байна. Кесар хагалгаагаар төрсөн /125/ 23.8 хувийг эзэлж байна

Хүүхдийн эрүүл мэнд

2021 оны 4 сард Аймгийн хэмжээнд 531 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 24 хүүхдээр буюу 4.3 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 194 буюу 52,3 хувь нь эрэгтэй, 189 буюу 47,7 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 2.8/15/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98,1 байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 4 сарын байдлаар нялхасын эндэгдлийн 11 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөнд 20,7 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11,7 промилоор өссөн ба улсын дундажаас өндөр байна. Улсын дундаж 11.0 промил байна. Нялхасын эндэгдэл АНЭ-6, Бор-өндөр-1, Галшар-1, ХБУ-1, Дадал-1, Цэгцүүлэн ДОМ ӨЭМТ-1 тус тус эндсэн байна. Гэрийн эндэгдэл 4 тохиолдол гарсан байна.
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 63,6 хувь нь эрэгтэй хүүхэд байна.
5 хүртэлх насны эндэгдэл 1000 амьд төрөлтөд 29,9 байна. Улсын дундаж 12.8 промил байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

2021 оны эхний 4 сарын байдлаар 5 хүртэлх насандаа эндсэн 12 тохиолдол бүртгэгдсэн байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл: төрөх үеийн бүтэлт-2, нярайн амьсгалын гачаал-2, нярайн тархины хямрал-1, төрөлхийн гажиг-1, хатгалгаа-2, мэдрэлийн тогтолцооны өвчин-2, осол гэмтэл-1 гэсэн шалтгаантай байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтанд шинээр 613 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 93.0 хувь нь эхний 3 сартайд, 6.3 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 0,7 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 94,6 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсанаас 4,6 хувь нь цус багадалттай байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 401 буюу 65,4 хувь нь эерэг-10, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 399 буюу 68,6 хувь, эерэг-0, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 595 буюу 97,1 хувь, эерэг-4, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 95.6 хувь тус тус хамрагдсан байна.

Нас баралтын үзүүлэлтүүд

2021 оны эхний 4 сарын байдлаар нийт нас баралтын 126 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 18 тохиолдлоор нэмэгдсэн ба 90 буюу 71,4 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 1,60 байна.

Нийт нас баралтын 17,5 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 45,5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын /42/33.3 хувийг эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 25 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 19,8 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 3,2 байна.

2021 оны 4 сарын байдлаар артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 7605 /16,4/ хүн хамрагдаж 60.7 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 47 байна. Чихрийн шижингээр онош батлагдсан 7 тохиолдол байна.

Хөхний эрт илрүүлэг үзлэгт 22,2 хувь, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 10.2 хувийн хамралттай байна.

Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

Аймгийн хэмжээнд 2021 оны 4 сарын байдлаар эмнэлэгт 5713 хүн хэвтэн эмчлүүлж нийт 42400 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,4 байна.

Амбулаторит эхний 4 сарын байдлаар 108232 үзлэг хийгдсэний 27,2 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 47,1 хувийг өвчний учир амбулаторит, 14,6 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 11,0 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 24979 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 4407 өвчлөлөөр өссөн үзүүлэлттэй байна.

2021 оны 4 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 588 тохиолдол бүртгэгдсэнээс /324/70,4 эрэгтэй, /136/29,6 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /126/27.4%, амьгүй механик хүчин өртөх /95/20,6%, хүчирхийлэл /78/ 16.9% зам тээврийн осол /72/15.6%, түлэгдэлт /48/ 10,4%, тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 4 сарын байдлаар 8392 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 18,1% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оноос 0,9 хувиар өссөн байна. Осол гэмтлийн 157 дуудлага бүртгэгдсэн байна.

10000 хүн амд ногдох халдварт өвчин
2021 оны эхний 4 сарын байдлаар

Аймгийн хэмжээнд 2021 оны 4 сарын байдлаар 164 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 20,9 ногдож байна. /Улсын дундаж 81,0/ Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

Нийт халдварт өвчнүүд дотор БЗДХ /59/ 35,9 хувь, сүрьеэ /30/ 18,3 хувь, салхинцэцэг /10/ 6,1 хувь, гепатит /2/ 1,2 тохиолдол гарч тус тус бүртгэгдсэн байна

Халдварт өвчин бүтэц



БЗДХ-ын 59 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 7,5 байна. БЗДХ-ын дотор т эмбүү /29/, гонококкт халдвар /14/, трихомониз /16/, тохиолдол бүртгэгдэж урьд оноос 50 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. .